

Жижиг, дунд бизнесийн зөвлөх үйлчилгээ
“Зөвлөх үйлчилгээний бизнесээ хөгжүүл” цуврал сургалт

Зөвлөх үйлчилгээний бизнесээ
өргөжүүлж, хөгжүүлэхийг хүсч
байна уу? *Хэрхэн хийх арга замыг
мэдэж авна уу.*

Бизнесийн хэрэгцээ шаардлагад дүн шинжилгээ хийхээс эхлээд амжилттай төсөл боловсруулах чадвар эзэмших хүртэл өөрийн туршлага, ур чадвараа ашиглан зөвлөх үйлчилгээний бизнесээ эхлэх, өргөжүүлэх, ашиг орлоготой ажиллахад шаардлагатай ур чадваруудыг эзэмшээрэй.



Жижиг, Дунд Бизнесийг Дэмжих баг
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
М-Си-Эс Плаза, 3 давхар, Сөүлийн гудамж 4А, Улаанбаатар 14251, Монгол улс
Утас: +976 11 319278 Факс: +976 11 315844
Э-шуудан: knowhowmongolia@ebrd.com
Вебсайт: ebrd.com/knowhow



European Bank
for Reconstruction and Development


Зөвлөх үйлчилгээний бизнесийг хэрхэн эхлүүлэхээс эхлээд тэргүүн туршлагыг нэвтрүүлэх хүртэл арга замыг бид мэднэ.

Зөвлөх үйлчилгээний бизнесийг хэрхэн эхлүүлэхээс эхлээд тэргүүн туршлагыг нэвтрүүлэх хүртэл арга замыг бид мэднэ.

“Зөвлөх үйлчилгээний бизнесээ хөгжүүл” сургалт нь үр дүнтэй зөвлөх үйлчилгээг хүргэх болон зөвлөх үйлчилгээний бизнесийг амжилттай эрхлэхэд шаардлагатай гол үр чадварууд, эх үүсвэр, арга хэрэгслээр хангадаг цуврал сургалтууд юм.

Эдгээр сургалтууд нь танд зөвлөх үйлчилгээний бизнесээ эхлүүлэхээс эхлээд ашиг орлоготой ажиллахад шаардлагатай “ноу-хау”-г өгөх ба жижиг, дунд бизнес эрхлэгчид төлбөр төлөхөд бэлэн өндөр чанартай зөвлөх үйлчилгээг үзүүлэхэд та бүхэнд туслах болно.

Таны туршлага ямар хэмжээнд байхаас үл хамааран бид танд зорилгодоо хүрч, зөвлөх үйлчилгээний бизнесээ тогтвортой эрхлэхэд тань тус болох зөвлөх үйлчилгээний арга хэрэгсэл



болон үндсэн зарчмуудын талаар хамгийн шилдэг танхимын сургалтуудыг санал болгож байна.

Та энэхүү мэдлэгийг ашиглан мэргэжлийн зөвлөхөөр ажиллахаар сонирхож буй мэргэжилтэн, эсвэл зөвлөхийн үр чадварыг сайжруулахыг эрмэлзэж буй залуу зөвлөх, эсвэл шинэ мэргэшил эзэмшихийг хүсч буй зөвлөх үйлчилгээний фирмийн ахлах ажилтан, эсвэл бизнесийн загвараа сайжруулж, зөвлөх үйлчилгээний бизнесээ өргөжүүлэн тэлэхийг хүсч буй компанийн захирлын аль байх нь хамаарахгүйгээр өөрийн түвшинг ахиулахад тохирсон сургалтуудад хамрагдаарай.

Зургаан төрлийн сургалт бид санал болгож байна:

- Зөвлөх үйлчилгээний бизнесээ эхлүүлэх
- Менежментийн зөвлөх үйлчилгээний үндэс
- Зөвлөх үйлчилгээний бизнесийг удирдан зохион байгуулах
- Зөвлөх үйлчилгээний маркетинг ба борлуулалт
- Зөвлөх үйлчилгээнд зориулсан бизнесийн дүн шинжилгээ
- Зөвлөх үйлчилгээний төслийн удирдлага.

Та хэрэгцээ шаардлагаасаа хамааран нэг эсвэл дөрөв, бүр зургаан сургалтанд бүгдэд нь ч хамрагдах боломжтой. Биднийг дэмждэг доноруудын тусламжтайгаар хөнгөлөлттэй үнээр сургалтуудаа явуулдаг. Сургалтуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл болон хэрхэн бүртгүүлэх талаар бидэнтэй утас болон имэйлээр холбогдох эсвэл www.ebrd.com/knowhow/consultant хаягаар орж танилцана уу.

Зөвлөх үйлчилгээний үндэс суурь

Менежментийн зөвлөх үйлчилгээний үндэс

Энэхүү 5 өдрийн сургалтаар менежментийн зөвлөх үйлчилгээний үндсэн асуудлуудын талаар бүрэн ойлголттой болно. Амжилттай бизнесийн төсөл боловсруулахаас эхлээд хэрэглэгчийн харилцааг удирдах болон төслийн менежмент хүртэл салбарын стандартад нийцсэн өндөр чанартай зөвлөх үйлчилгээг хэрхэн хүргэх талаар суралцаарай.

Зөвлөх үйлчилгээний арга туршлага

Зөвлөх үйлчилгээний бизнес эхлүүлэх

Хэрэв та өөрийн бизнесийн мэдлэг эсвэл мэргэжлийн туршлага, үр чадвараа жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хэрэгтэй гэж боддог бол энэхүү 2 өдрийн сургалт нь танд өөрийн мэдлэг, үр чадвараа хэрхэн амжилттай зөвлөх үйлчилгээний бизнес болгон хувиргахыг зааж сургах болно. Бизнесээ хэрхэн хууль ёсоор эхлүүлэхээс эхлээд анхны захиалагчаа олох, бизнесийн удирдлагын чухал үр чадварууд эзэмших хүртэл жижиг, дунд бизнес эрхлэгчид төлбөр төлж авахад бэлэн өндөр чанартай зөвлөх үйлчилгээг үзүүлэхэд мэдлэг, үр чадвараа хэрхэн ашиглах талаар суралцаарай.

Зөвлөх үйлчилгээний бизнесийг удирдан зохион байгуулах

Зөвлөх үйлчилгээний бизнес эзэмшигч ба менежерүүдэд зориулсан энэхүү 3 өдрийн сургалтаар та бизнесийн удирдлагын үр чадвараа хөгжүүлээрэй. Шинэ үйлчлүүлэгч нарт хүрч ажиллахаас эхлээд нөөц бололцоо ба ажилтануудын авьяас чадварыг удирдан зохион байгуулах хүртэл бизнесээ хэрхэн үр дүнтэй, өрсөлдөхүйц, үр ашигтай байлгах талаар та суралцана.

Зөвлөх үйлчилгээний маркетинг ба борлуулалт

Ихэнх жижиг, дунд бизнесийн эрхлэгчдийн хувьд гадны зөвлөх авч ажиллуулах талаар өмнө нь огт бодож байгаагүй байдаг. Энэхүү 4 өдрийн сургалтаар та өөрийн бизнесээ таниулахаас эхлээд амжилттай бизнесийн төсөл боловсруулах, үйлчлүүлэгчийн харилцаа холбоог хэрхэн удирдан зохион байгуулах зэрэгт суралцах ба танд зөвлөх үйлчилгээгээ илүү өргөн хүрээнд, үр дүнтэй сурталчилж, илүү олон үйлчлүүлэгчтэй болоход тусална.

Зөвлөх үйлчилгээний ахисан түвшний үр чадварууд

Зөвлөх үйлчилгээнд зориулсан бизнесийн дүн шинжилгээ

Оновчтой бизнесийн шинжилгээний арга хэрэгслийг сонгохоос эхлээд хэрхэн ашиглах хүртэл үйлчлүүлэгч нарынхаа тулгамдсан асуудлын учир шалтгааныг хэрхэн тодорхойлж, тохиромжтой шийдэл санал болгох талаар та суралцана. Эдгээр арга хэрэгслүүдийг хэрхэн хэрэгжүүлэхэд илүү чиглэсэн энэхүү 3 өдрийн сургалтаар та зөвлөхийн ба дүн шинжилгээ хийх үр чадвараа сайжруулснаар үйлчлүүлэгчийнхээ хүсэн хүлээсэн үр дүнг бий болгоход танд тусална.

Зөвлөх үйлчилгээний төслийн менежмент

Энэхүү 4 өдрийн сургалтаар та зөвлөх үйлчилгээг чанарын өндөр түвшинд үр дүнтэй хүргэхэд шаардлагатай төслийн удирдлагын үр чадваруудыг эзэмшинэ. Танд үйлчлүүлэгч нарынхаа хэрэгцээ шаардлагын дагуу илүү нарийн төвөгтэй, томоохон зөвлөх үйлчилгээнүүдийг үзүүлэхэд тус болох төрөл бүрийн санаа, аргачлал болон бүтэц, үйл явцын арга хэрэгслээр хангана.